



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 67449

Улаанбаатар хот

Б.Саруултуяад сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.16, 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны А/1300 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Улсын бүртгэлийн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам”-ийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.6, 10.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Батбаатарын Саруултуяа нь Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь Хяналт шалгалтын газрын 2023 оны 62 дугаар дотоод албан бичиг, хяналтын улсын байцаагчийн 2023 оны 3553 дугаар дүгнэлт, өөрийн гаргасан тайлбараар тогтоогдсон тул түүнд 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс албан тушаалын цалингийн хэмжээг гурван сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Б.Саруултуяад үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахих талаар анхааруулахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /П.Мөнхбаатар/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

- 142302797